

ÄÄÐ×ÈÄ

1. Äàðàí ñòì ùí ÈÒÛ-ùí ээлжит бус 4 дүгээр бодàëääàí 2
2. Äàðàí ñòì ùí ÈÒÛ-ын Òýðäëçéýã-дийн хуралдаан 3- 6
3. Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс хэрэгжүүлсэн ажлууд 7 -24
4. Дархан сумын ГХУСА33-ийн хуралдаан, хийгдсэн ажлууд 25-29

ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН 7 ДАХЬ УДААГИЙН ЭЭЛЖИТ БУС 4 ДҮГЭЭР ХУРАЛДААН БОЛОВ

Дархан сумын ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит бус 4 дүгээр хуралдаан өнөөдөр /2017.05.12/ боллоо. Хуралдаанд ирвэл зохих 31 төлөөлөгчөөс 26 төлөөлөгч оролцож 83.8 хувийн ирцтэйгээр хуралдлаа.



Хуралдаанаар Дархан сумын 2017 оны төсөвт тодотгол хийх тухай асуудлыг хэлэлцэж Дархан сумын тодотгосон төсвийн орлогыг 2.280.6 сая , зарлагыг 1.685.9 сая, сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 594.7 сая, ОНХСанг 696.4 сая, улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих байгууллагын зарлагыг 23.906.5 сая төгрөгөөр тус тус баталлаа.



Мөн Олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс Дархан сумын ОНХСанд олгосон урамшууллын 352.4 сая төгрөгөөр шинээр 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсвийн тодотголын төсөлд тусгасныг төлөөлөгчид баталсан юм.

ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааныг 2017 оны 2, 3 дугаар улиралд 5 удаа хуралдаж, 15 гаруй асуудлыг авч хэлэлцсэн байна. Үүнд:



1. Гудамжнуудын байршил, нэр хилийн заагийг тодотгох, нэрлэх тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай
2. Хаяг, дугаар олгох тухай
3. Хамтарсан баг байгуулах тухай
4. Багийн ИНХ-ын дарга нарын ажлыг дүгнэх, мэдээ тайлан ирүүлэх журмыг батлах тухай
5. Дархан сумын ИТХ-ын 7 дахь удаагийн сонгуулийн ээлжит бус 4 дүгээр хуралдааны товыг зарлах тухай
6. Ном солилцох өдөртэй болох тухай
7. Дархан сумын 2017 оны батлагдсан төсөвт тодотгол хийх тухай
8. Дархан сумын ИТХ-ын дэргэдэх ГХУСА33-ийн бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
9. Төрийн дээд шагналд уламжлах тухай



Хуралдаан хэлэлцсэн асуудлуудаараа тогтоол гаргалаа.

МЭДЭЭЛЭЛ



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 33

Дархан

Номын өдөртэй болох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалтыг үндэслэн, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Дархан-Уул аймгийн Төв номын сангийн хамт олны санаачилгыг дэмжиж, сар бүрийн 17-ны өдрийг “Номын өдөр” болгосугай.

Хоёр. “Номын өдөр”-ийг тогтмол зохион байгуулж ажиллахыг Төв номын сангийн захирал /Д.Цэрэндаваа/ болон боловсрол, соёлын байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ



d:Hural/togtool



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 29

Дархан

Хамтарсан баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9, 25 дугаар зүйлийн 25.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хамгаалах үйлчилгээг цаг алдалгүй шуурхай үзүүлэх Дархан сумын "Хамтарсан баг"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Багуудын "Хамтарсан баг"-ийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд тайлагнахыг Дархан сумын Засаг дарга /Б.Азжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.БАЛЖИННЯМ



d:Hural/togtool

МЭДЭЭЛЭЛ

“ХОТЫН СОЁЛ- ХОГГҮЙ ОРЧИН”

Аймгийн Засаг даргын 01, 02 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дархан-уул аймгийн Зүүний Хүчний Холбооноос санаачлан 2017 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр “ХОГ БОЛ МӨНГӨ, ХОГ БОЛ БАЯЛАГ”, “ХОТЫН СОЁЛ-ХОГГҮЙ ОРЧИН” их цэвэрлэгээг зохион байгуулав.



Дархан хүнс ХК-ийн араас хойд Дархан хаалга хүртэл 6 км урт, 100 м-ээс 1,5 км хүртэл өргөн газрын хогийг түүж, 4 машин 32 м3 дахин ашиглах боломжтой хогийг ачуулж, хогийн цэг орчмоос түүсэн 10 м3 орчим хогийг хогийн цэг рүү шууд зөөж, асгасан байна.



Бүх нийтийн цэвэрлэгээнд Зүүний Хүчний холбооны 11 Тэргүүлэгч, аймгийн ЗДТГ-ын 31 албан хаагч, Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгч, багийн ИНХ-ын дарга нар, аймгийн БСУГ –ын 5 албан хаагч, ерөнхий боловсролын сургуулиудын нийт 621 багш ажилтнууд, аймгийн НААҮГ-ын 11 ажилтан, 4 авто машин, аймгийн МХГ-ын 28 алба хаагч нийт 751 иргэн оролцож урд Дархан хаалга орчим газрыг цэвэрлэсэн байна. Тэд 8м3 хог шуудайлж аймгийн НААҮГ-т дуудлага өгч ачуулжээ. Ирэх долоо хоногийн амралтын өдрүүдэд эрүүл мэндийн салбарынхан “Хог бол мөнгө, Хог бол баялаг” их цэвэрлэгээг үргэлжлүүлэх юм байна.

МЭДЭЭЛЭЛ

БОЛЗОШГҮЙ ГАМШИГ ОСЛООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛСАНД ИРГЭД ТАЛАРХАЖ БАЙНА

Дархан сумын 5 дугаар багийн Үндсэн тосгоны 42, 46, 47, 49, 50, 51 дүгээр байруудын гаднах моднууд насжилт өндөртэй, 8 метрээс дээш өндөр ургасан, хүчтэй салхи шуургатай үед өндөр хүчдэлийн цахилгааны шугамууд шүргэлцэж, галын аюул гарах эрсдэл өндөр байсан тул мэргэжлийн байгууллагын туслалцаа авч, моднуудыг намсгаж тайруулах хүсэлтийг Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, ГХУСАЗЗ-өөс 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 60 тоот албан бичгээр аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлж,



тус газрын Гал түймрийг унтраах 54 дүгээр ангийн 24 албан хаагч 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс 04 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд ЗИЛ 131 загварын 29-15 ДАА улсын дугаартай автомеханик шатны автомашинтай ажиллаж, 43 ширхэг улиас модыг тайрч, иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан байна.

Ийнхүү учирч болзошгүй гамшиг ослоос иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах талаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажилласан аймгийн Онцгой байдлын газар, Гал түймрийг унтраах 54 дүгээр ангийн нийт бие бүрэлдэхүүнд 5 дугаар багийн үндсэн тосгоны дээрх байруудын иргэд талархал илэрхийлж, Та бүхний цаашдын ажил үйлст нь амжилт хүссэнийг дамжуулж байна

ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧ, БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ЗӨВЛӨЛГӨӨН БОЛОВ

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгч, багийн ИНХ-ын дарга нарын хамтарсан зөвлөлгөөн 2017 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр болж, дараах асуудлыг хэлэлцэв. Үүнд:



- ✓ Аймгийн БСУГ-ын 2017-2020 онд хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны тухай
- ✓ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн товч танилцуулга
- ✓ ИТХ-ын Төлөөлөгчидг багийн ИНХ-ын дарга нар сонгогдсон багийн цэцэрлэг, сургуулиудын үйл ажиллагаатай танилцах

Аймгийн БСУГ-ын 2017-2020 онд хэрэгжүүлэх бодлого үйл ажиллагааны тухай сонсоод, Төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нар сонирхсон асуултандаа хариулт авч, хүүхдийн хүмүүжил төлөвшлийн асуудалд онцгойлон анхаарахыг хэлсэн үгэндээ онцолж байв.



Зөвлөгөөн дээр гарсан саналуудыг нэгтгэн, аймаг, сумын Засаг дарга, БСУГ-ын удирдлагуудад хүргүүлэхээр болов.

ДАРХАН СУМЫН 8, 13 ДУГААР ЦЭЦЭРЛЭГ, 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгч Б.Даваасамбуу, Д.Туяа, багийн ИНХ-ын дарга Ц.Лхагвасүрэн, Ц.Мөнхбаатар нар 2017 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр 8, 13 дугаар цэцэрлэг, 4 дүгээр сургуулийн үйл ажиллагаатай танилцлаа.



Дархан сумын 13 дугаар цэцэрлэгийн арга зүйч, багш нартай уулзаж, санал сэтгэгдлийг нь сонслоо. Тус цэцэрлэг Дархан сумын 1, 2, 3 дугаар багийн 400 гаруй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа “Гэр бүлэг”-т 30, ширээ нурууны цэцэрлэгт 80 хүүхэд тус тус суралцаж байна.

Өнгөрсөн хугацаанд өөрсдийн боломжоор анги болгонд шугам тавьж ус зөөх асуудлыг шийдсэн, багш нарын хувцасны өрөө, гал тогооны угаалгын өрөө, цагаан хэрэгслийн угаалгын болон хүүхдийн бие засах өрөөнүүдийг шийдвэрлэж чаджээ.

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нарт тус цэцэрлэгийг төвийн шугаманд холбох, цалингийн сан хүрэлцэхгүй, өртэй байгаа асуудлаа шийдвэрлүүлэх талаар ярьж байна.



Дархан сумын 8 дугаар цэцэрлэг нь 2015 оны 9 сард ашиглалтанд орж, 150 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай ч өнөөдөр 200 хүүхдэд сургуулийн өмнөх боловсролыг олгон, 6 бүлэг 25 багштайгаар үйл ажиллагаа явуулж байна. Эцэг эхчүүдийнхээ

МЭДЭЭЛЭЛ

хүчээр цэцэрлэгийн хашаа барьж, камержуулах ажлуудыг хийсэн байна. Төлөөлөгч, багийн ИНХ-ын дарга нар 8 дугаар цэцэрлэгийн эрхлэгчтэй санал солилцож байхад

- ✓ Цэцэрлэгийн гадна хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, анги доторх хүүхдийн тоглоомын хүрэлцээг нэмэгдүүлэх
- ✓ Төв замаас цэцэрлэг рүү салсан замыг сайжруулах, тэмдэг, тэмдэглэгээтэй болгох
- ✓ Хүүхдийн чийгжүүлэлтийн танхимтай болох
- ✓ Төвлөрсөн дулаанд холбох зэрэг асуудлуудыг тавьж байна.



Дархан сумын 4 дүгээр сургууль нь нийт 60 багш 1024 сурагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. Өнгөрсөн хугацаанд сургуулийн захиргаа эцэг эхчүүд, сурагчдын дунд хүүхдийн хүмүүжил, төлөвшил иргэний боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтуудыг тогтмол явуулж иржээ.

Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нарт хичээлийн эрхлэгч сургуулийг төвийн шугаманд холбосноор зориулалтын гал тогоо, бохир зэрэг асуудлыг шийдэх боломжтой тухай ярьж байна.

ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР ХИЙГДСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮЗЭЖ ШАЛГАВ

Дархан сумын ИТХ-ын дэргэдэх Сумын хөгжлийн бодлогын хорооноос 2016 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь үзэж танилцах, үнэлэлт дүгнэлт өгч ажиллажээ. Батлагдсан ажлуудын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөх, өмчийн бүртгэл, хадгалалт хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх зорилгоор сумын ИТХ-ын Төлөөлөгчид ажлын хэсгийг байгуулсан байна.

Ажлын хэсгийн гишүүд нийт 12 ажил буюу хүүхдийн тоглоомын талбай, зам, гэр хорооллын гэрэлтүүлэг, явган хүний зам, нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт зэрэг ажлуудын гүйцэтгэлд хяналт шалгалт хийлээ. Энэ үеэр багийн Засаг дарга болон ИНХ-ын дарга, иргэдийн төлөөлөл зэргийг байлцуулан санал хүсэлтийг сонсож ажиллав.



Сумын хөгжлийн бодлогын хорооноос ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэлийн тайлан, хэрэгжсэн ажлыг хүлээж авсан комиссын акт, өмчид бүртгэж авсан, ашиглалтын талаар гаргасан захирамж тайлан баланс зэрэг баримт бичиг зэрэг гүйцэтгэлийн ажлыг үзэж танилцлаа.



Хөрөнгө мөнгө зарлагдаж хийсэн бүтээн байгуулалтыг нүдлэн хамгаалах, эзэнтэй болгох асуудал чухал. Хүүхдийн тоглоомын талбай, зам, гэрэлтүүлэгүүд

эвдэрч гэмтсэн асуудлууд гарсан байна. Иймд Сумын хөгжлийн бодлогын хорооноос ажлын хэсгийн дүгнэлт болоод засварлах ажлын жагсаалтыг бүтээн байгуулалт тус бүрээр гаргаж Дархан сумын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгчээ.

“АРД ТҮМНЭЭ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ” ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИНЭ

Дархан сумын ИТХ-ын 2017-2020 онд баримтлах үйл ажиллагааны үндсэн чиглэлд тусгагдсан нэг чухал ажил нь иргэдэд зөв амьдрах мэдлэг, дадал зуршлыг хэвшүүлэх явдал юм. Дарханд анх удаа “Соён гэгээрүүлэх хөтөлбөр” төслийг Дархан сумын ахмадын хорооны дарга Д.Тожил, З.Ням-Очир нар санаачлан хэрэгжүүлж байна.

Төслийн баг өнөөдөр 2017.08.29- ны өдөр Дархан сумын ЗДТГ-ын хуралдааны танхимд сумын ИТХ-ын Төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нарт мэдээлэл хийж, хөтөлбөрийн хүрээнд нийгэмд өөрийн үүрэг хариуцлагыг ухамсарласан бие хүнийг төлөвшүүлэх зорилгоор иргэний боловсролыг дэмжихэд чиглэсэн сургалтуудыг явуулах талаар мэдээллээ.



Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням сургалтын эхэнд хэлсэн үгэндээ : Та бид иргэдийнхээ сэтгэхүйд хөрөнгө оруулалт хийж, өөрчилж байж , “ Ухаалаг Дархан”-ыг бүтээн байгуулна. Энэ төсөл орон нутагт магадгүй улсын хэмжээнд анхных нь бөгөөд Дархан хотод үр дүнтэй хэрэгжүүлж “бренд” ажил болгож чадна гэдэгт итгэлтэй байна гэв. Төслийн танилцуулга хийх үеэр төрийн анхан шатны нэгжид ажиллах багийн Засаг дарга болон ИНХ-ын дарга, сумын ИТХ-ын Төлөөлөгч нар Соён гэгээрүүлэх хөтөлбөрийг цаг үеэ мэдэрсэн, наад зах нь иргэд орчноо бохирдуулах, бүдүүлэг үг яриа гаргах явдал үгүй болж хотын иргэдийг бэлтгэхэд үр дүн өгнө хэмээн онцлон хэлж байв.

“Соён гэгээрүүлэх хөтөлбөр” 2017 онд зуун залуу сургагч багш бэлтгэх, баг тус бүрээр бүсчилсэн сургалт, танхимын болон ганцаарчилсан, бүлэг, аж ахуй нэгжүүдэд

сургалт зохион байгуулж 3000 гаруй иргэдийг хамруулах зорилт тавьжээ. Хөгжлийг тодорхойлогч нь хүн учраас иргэдээ мэдлэг мэдээллээр хангах соён гэгээрүүлэх сургалтанд хамруулж бурхантын хөндийд оюун ухааны үрийг тарихаар төслийн багийнхан ажилдаа орлоо.

БУЧОН ХОТЫН ИТХ-ЫН ДАРГА ТЭРГҮҮТЭЙ ТӨЛӨӨЛӨГЧИД ДАРХАН ХОТОД АЙЛЧЛАВ

Дархан-Уул аймгийн Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням болон ИТХ-ын Тэргүүлэгчдийн урилгаар Бүгд найрамдах Солонгос улсын Кёнги аймгийн Бүчон хотын ИТХ-ын дарга ноён Кан Дун-Гу болон ИТХ-ын хороодын дарга, төлөөлөгчид, ажлын албаны ажилтнуудаас бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй баг манай аймагт албан ёсны айлчлалыг 2017 оны 8 дугаар сарын 14- 16-ний өдрүүдэд хийлээ.



БНСУ-ЫН БУЧОН ХОТЫН ИТХ, ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН НАЙРАМДАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА БОГИНО ХУГАЦААНД АМЖИЛТТАЙ ХӨГЖИЖ БАЙНА

Бүгд Найрамдах Солонгос улсын Кёнги аймгийн Бүчон хотын ИТХ-ын дарга тэргүүтэй Төлөөлөгчид айлчлалынхаа эхэнд Дархан сумын ИТХ, Дархан сумын ЗДТГ-ын бүтэц бүрэлдэхүүнтэй танилцлаа. Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням хэлсэн үгэндээ: Хоёр хотын найрамдалт хамтын ажиллагаа 2015 оны 7 дугаар сараас эхэлсэн бөгөөд Дархан сумын ИТХ-ын хоёр бүрэн эрхийн хугацааг дамнан өнөөдрийг хүртэл амжилттай хөгжиж буйд баяртай байгаагаа илэрхийлэв. Түүнчлэн өнгөрсөн богинохон хугацаанд Бүчоны ИТХ-ын Төлөөлөгчдийн чин сэтгэлийн тусламж дэмжлэгээр үр дүнтэй олон ажлуудыг хамтран хэрэгжүүлсний дотроос Дархан сумын хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдэд чихний дунгийн суулгацын мэс заслыг үнэ төлбөргүйгээр хийлгэн, тэдэнд амьдралын баяр баясгаланг бэлэглэсэнд сэтгэл хангалуун байгаагаа онцлон хэллээ.

МЭДЭЭЛЭЛ

Уулзалтын үеэр Дархан сумын ИТХ-ын танилцуулга хийлээ. Дархан сумын ИТХ нь нийт 31 төлөөлөгч, 7 Тэргүүлэгчтэй. Төлөөлөгчид 5 хороонд хувиарлагдан ажилладаг. Нийт төлөөлөгчдийн 29 хувь нь эмэгтэй төлөөлөгчид байна. Хурлын дэргэд Дархан сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл үйл ажиллагаа явуулдаг.



Бүчон хотын ИТХ нь 28 төлөөлөгчтэй. Санхүү соёл урлагийн хороо, Засаг захиргаа, нийгмийн халамжийн хороо зэрэг 4 хороо үйл ажиллагаа явуулдаг байна. Айлчлалын бүрэлдэхүүнд 2 хорооны дарга багтжээ. Бүчон хот нь 870 мянган хүн амтай. Бүгд найрамдах Солонгос улсын нийслэл Сөүл хоттой хил залгаа оршдог. Аж үйлдвэрийн салбарын 80 хувь нь хүнд үйлдвэрлэл байдаг. Тэр дундаа Гэрэлтүүлэг, Робот, Химийн чиглэлийн үйлдвэрүүд өндөр хөгжжээ. Хятад болон Дундад Азийн олон оронтой хамтран ажилладаг байна. Монгол улстай тэр дундаа Дархан сумын ИТХ-тай ах дүү найрамдалт харилцаагаа улам өргөжүүлэх боломж бүрэн дүүрэн бий гэдэгт итгэл төгс байгааг ноён Кан Дун-Гу онцолсон юм.

“НАРНЫ ХҮҮХДҮҮД” ТӨВИЙН ХҮҮХДҮҮДЭД 1 САЯ ТӨГРӨГИЙН ХИЧЭЭЛИЙН ХЭРЭГЛЭЛ БЭЛЭГЛЭЛЭЭ

БНСУ-ын Кёнги аймгийн Бүчон хотын ИТХ-ын дарга ноён Кан Дун-Гу болон тус хотын ИТХ-ын төлөөлөгчид, хороодын дарга нар, ажлын албаны ажилтнууд “Нарны хүүхдүүд” төвөөр зочиллоо.

МЭДЭЭЛЭЛ

Тус төв 2000 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Өнөөдрийн байдлаар 40 хүүхэд “Нарны хүүхдүүд” төвд амьдарч байна. Төвийн багш нар хүүхдүүдэд зөвхөн асрамж халамж үзүүлэхээс гадна амьдрах ухаанд сурган, авьяас чадварыг нь нээн хөгжүүлэхэд анхааран ажилладгаараа онцлогтой.



Оёх, зурах, язгуур урлагийн тоглолт үзүүлэх зэрэг өөрсдийн сурсан мэдсэнээрээ сурагчид тодорхой хэмжээний мөнгө олж түүнийгээ хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцас гээд шаардлагатай зүйлээ авахад зарцуулдаг гэв. Харин энэ удаа тэдэнд 1 сая төгрөгийн хичээлийн хэрэглэлийг Бүчон хотын ИТХ-аас бэлэг болгон өгсөнд багш, сурагчид баяртай байлаа.

БҮЧОН ХОТЫН ИТХ-ЫН ДАРГА, ТӨЛӨӨЛӨГЧИД НААҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА

Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Бүчон хот хогны менежментээрээ улсдаа тэргүүлдэг аж. Тус хот нь 870 гаруй мянган хүн амтай. Нэг өдөрт 240 гаруй тонн хогийг ачдаг юм байна. Харин манай аймаг хоногт 400м³ буюу 140 тонн хог ачдаг. Ачсан хогоо зөвхөн булж дарах технологиор устгасаар 50 иад жил болж байгааг НААҮГ-ын дарга Ж.Дорждэрэм хэлэв. Гэхдээ олон улсын жишгийн дагуу хогийг шатааж 2000мвт эрчим хүчийг үйлдвэрлэх станц байгуулахаар төлөвлөн, уг ажил гэрээ хэлэлцээрийн шатанд явж байгааг ч танилцуулсан юм.

Бүчон хотод хогийг устгахдаа уламжлалт арга буюу газарт булж дарах, шатаах, дахин боловсруулах буюу шахмал түлш үйлдвэрлэх гэсэн 3 арга, технологийг ашигладаг байна. Аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний газрын /НААҮГ/ удирдлагууд болон Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын /ИТХ/ зүгээс Бүчоны Хог боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаатай газар дээр нь

танилцан, хогны менежментээ сайжруулах талаар туршлага судлах хүсэлтэй байгааг хэллээ.



Найрамдалт хамтын ажиллагааныхаа хүрээнд Монголын талаас тавьсан саналыг дараа дараагийнхаа ажилд хэрэгт тусган, биелэлээ олоход анхаарал хандуулна гэдгээ БНСУ-ын Кёнги аймгийн Бүчон хотын ИТХ-ын дарга ноён Кан Дун-Гу хэлэв.

ИРГЭДИЙН ОРОЛЦООГ САЙШААН УРАМШУУЛАВ

Дархан сумын 15 дугаар багийн 5 дугаар хэсгийн 3 дугаар гудамжны айл өрхүүд хамтарч “Иргэдийн оролцоо хөгжлийн түлхүүр” бүлэг байгуулан өөрсдийн оршин сууж байгаа байгаа гудамжаа тохижуулжээ.

Иргэд гудамжиндаа явган хүний зам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг хийсэн байна. Иргэдийн оролцоо, зүтгэлийг сайшаан БНСУ-ын Бүчон хотын ИТХ-ын дарга, төлөөлөгчид “Жишиг гудамж”-ны өрх бүрд БНСУ-д үйлдвэрлэсэн бичил электрон хэрэгсэл цэнэглэх боломж бүхий нарны энергээр цэнэглэгддэг гэрэлтүүлгийг бэлэглэсэн юм.



ДАРХАН СУМЫН 1,2,3 ДУГАР БАГИЙН ИРГЭД “СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ СУРГАЛТ”- НД ХАМРАГДАВ

МЭДЭЭЛЭЛ

Аймаг, сумын ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Соён гэгээрүүлэх хөтөлбөр”-ийн хичээл сургалт батлагдсан хуваарийн дагуу өнөөдөр 2017.09.26 ны өдөр Дархан сумын 1,2,3 дугаар багийн иргэд сургалтанд хамрагдав. Сургалтад тосгоны 1-3 багийн 50 орчим иргэд оролцлоо. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн багш О.Мөнхбаяр “Өрхийн санхүүгийн удирдлага” сэдвээр сонирхолтой хичээл оров.



Өрх бүр санхүүгийн орлого, зарлагаа тооцож хөтлөх, Мөнгөний үнэ цэнэ зэрэг сэдвээр жишээ баримтад тулгуурлан айл өрхийн төсвийг хэрхэн зөв зарцуулах талаар хичээл сургалтыг заасан нь иргэдэд ихэд таалагдаж байв. Түүнчлэн “Эрүүл мэндэд иргэн хүний оролцоо” сэдвээр эрүүл мэндийн газрын мэргэжилтэн С.Энхжаргал хичээл заасан байна. “Соён гэгээрүүлэх сургалт”-ын хичээл иргэдэд тун сонирхолтой өгөөжтэй байгааг иргэд онцлон хэлж байлаа. Мэдлэг оюунаа дээшлүүлэх эрмэлзлэлтэй цаашид хөгжих, ажил хийх хүсэл сонирхолтой иргэд, оюутан залуус гээд ажил мэргэжил, нас хүйс ялгахгүй үнэ төлбөргүйгээр Соён гэгээрүүлэх сургалтад хамрагдахыг урьж байна.

АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН ФОНД ШИНЭЧЛЭГДЭВ



Аймгийн төв номын санд иргэд, оюутан сурагчдад эрэлт ихтэй байдаг 291 боть шинэ номоор номын фондоо шинэчилсэн байна. Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгч нарын санаачлагаар “Ном хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж төсөв хөрөнгийг шийдвэрлэсэн байна. Дарханчуудынхаа оюун санаанд хөрөнгө оруулалт хийж "Ном хөтөлбөр" амжилттай хэрэгжүүлж, 5 сая төгрөгийн өртөгтэй 291 боть номыг аймгийн төв номын санд нийлүүлсэн байна. Дарханчууд төв номын сангаар зочлон Энэ нь уншигч олон түмэн, оюутан сурагчдын мэлмийг нээсэн, буянтай үйлс боллоо.

ДАРХАН СУМЫН ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН ХОРООНЫ ГИШҮҮД АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

Дархан-Уул аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаатай Дархан сумын Хүний хөгжил, Нийгмийн бодлогын хорооны гишүүд танилцав. Тус газрын дарга А.Амгалан сумын ИТХ-ын Төлөөгчид болон хороодын гишүүдэд байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулж, мэдээлэл хийв.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар 2017 онд 20 гаруй байгууллагатай хамтран ажиллав. Үүнээс 17 байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулан хүүхдийн эрхийн хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийх, гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг хангах, залуучуудын хөгжлийн асуудлуудыг шийдвэрлэхэд хамтран ажиллажээ.



Сумын ИТХ-ын дэргэдэх Хүний хөгжил, нийгмийн бодлогын хорооны гишүүд эрхлэх асуудлын хүрээнд тус газрын үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж

МЭДЭЭЛЭЛ

цаашид хамтран ажиллах гарцын талаар санал бодлоо илэрхийлж харилцан ярилцсан байна. Манай аймгийн тухайд “Түр хамгаалах байр”-ыг байгуулж, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд болон орон гэргүй хүүхдэд асрамж халамжийн үйлчилгээг хүргэх зайлшгүй шаардлагатайг хөндөж байв.

Түүнчлэн Нийгмийн ажилтнуудыг давтан сурган чадавхижуулах, Баг бүрт “Гэр бүлийн зөвлөгөө өгөх төв” байгуулах Анхан шатанд хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, Сургууль бүрийн эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Эцэг эхийн зөвлөл байгуулах”, “Зулзагын гол “ хүүхдийн зуслангийн хүүхэд амрах байрыг засварлах, их засвар оруулах зэрэгт анхаарч хамтран ажиллахыг хүслээ.



Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням болон сумын Хүний хөгжил, Нийгмийн бодлогын хорооны дарга С.Мөнхзул нар аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагааг бүхий л талаар дэмжин, хамтран ажиллахаа илэрхийлэв. Дашрамд дурьдахад : Гэр бүл хүүхэд залуучуудын газар энэ сард 22 төрлийн үйлчилгээнд 2430 хүүхэд хамруулсан байна.

“МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ “ТӨСЛИЙН БАГ ДАРХАН СУМАНД АЖИЛЛАВ

Монгол Улсын Их Хурлын тамгийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь ” төсөл орон нутгийн хурлын төлөөллийн болон хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх, төлөөлөгчдөд зориулсан үндэсний сургалтын хөтөлбөрийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх механизмыг бий болгох, иргэдийн оролцоог хангаж байгаа сайн туршлагыг дэлгэрүүлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн орчныг сайжруулах зорилт тавин ажиллаж байна.

МЭДЭЭЛЭЛ



Уг төслийн хүрээнд ИТХ-уудын хяналтын чиг үүрэг болон иргэдийн оролцоотой шийдвэр гаргах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тэтгэлэгт хөтөлбөр зарлаж Дархан-Уул аймгийн ИТХ-ын ажлын алба 4 сая төгрөгийн төсөл бичиж шалгарчээ. Төсөл хэрэгжүүлж буй аймгийн үйл ажиллагаатай танилцах, хяналт тавихаар Улаанбаатар хотоос төслийн зохицуулагч Г.Золжаргал, төслийн ажилтан Т.Чулуунцэцэг нар 2017.09.20 ны өдөр манай аймагт ажиллав. Үдээс хойш Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням хүлээн авч уулзав.



Энэ үеэр ИТХ-дад хэрэгцээ шаардлагатай үлгэрчилсэн дүрэм журам, сайн туршлагын эмхэтгэл, нутгийн удирдлагын талаарх иргэдийн боловсрол, хяналтын чиг үүргийг сайжруулах гарын авлага хэрэгцээтэй байгааг хөндөв ярив. Түүнчлэн төслийн багийхан Дархан сумын 18 багийн ИНХ-ын дарга нартай уулзалт хийсэн байна. Анхан шатны нэгжид ажиллах багийн ИНХ-ын дарга нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулах, тогтоол шийдвэрийг иргэдэд сурталчлах талд анхаарах, Багийн Засаг дарга, багийн ИНХ-ын дарга нарын ажлын уялдаа холбоог сайжруулах зэрэг олон асуудлын талаар харилцан ярилцлаа.

“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь “ төслийн зүгээс ирэх 10-11 сардаа багтаж Багийн ИНХ-ын дарга нарыг хамруулсан бүсийн хэмжээний сургалтыг зохион байгуулна гэсэн юм.

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ САЙН ТУРШЛАГЫГ СУДАЛЖ БАЙНА

2017 оны 9 дүгээр сарын 11-13 ны өдрүүдэд Дархан-Уул аймагт “Үндэсний хэмжээний сайн туршлага судлах арга хэмжээ” зохион байгуулагдаж байна. Уг арга хэмжээнд Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг, ОНТА, Сангийн яам болон 21 аймгаас сумдын төлөөлөл болон ирсэн нийт 41 хүн оролцож байна.

Зочид төлөөлөгчид өнөөдөр Дархан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудын талаарх мэдээллийг сонсож зарим ажлуудтай газар дээр нь явж танилцсан юм. Дархан сум нь 24 мянган өрхийн 84 мянга гаруй хүн амтай. Улсдаа хамгийн том 2 сумын нэг.



Тус суманд 2013-2017 онд Дархан сумын ОНХС-ийн нийт 6,8 тэр бум төгрөгөөр 71 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн. Тухайлбал сумын нийт хүн амын 65 хувь нь амьдардаг орон сууцны хороололд 7 байршилд 230 сая төгрөгөөр авто машины зогсоол хийгдсэн бол аймгийн 70, сумын 30 хувийн хөрөнгө оруулалтаар “Жишиг хороолол төсөл”-ийг 5 удаа амжилттай хэрэгжүүлжээ.

Үүний үр дүнд 5 багт дээд тал нь 1,2 тэр бум төгрөгөөр ногоон байгууламж, сандал сүүдрэвч, явган хүний зам бүхий иж бүрэн хүүхдийн тоглоомын талбайг авто зогсоолтой нь байгуулсан юм. Түүнчлэн нийтийн эзэмшлийн байруудын 80 хувьд нь фасад засвар хийгдсэнээс гадна инженерийн шугам сүлжээний засвар, камержуулалт зэрэг олон ажлуудыг хийжээ. Харин хүн амын 35 хувь нь амьдардаг гэр хорооллын багуудын замыг засахад 900 орчим сая төгрөгийг зарцуулсан, 600 сая төгрөгөөр 207 ширхэг өндрийн цамхагт гэрэл тавьсан гээд иргэдээс гарсан саналын дагуу хийгдсэн бодит ажлууд олон байна. Мөн гүний худаг, усан сан барих, хашаа гудамжны хаягжуулалт зэргийг ч хийжээ.



Гэр болон орон сууцны хороололд хийгдсэн нийтлэг ажлуудын тоонд цэцэрлэгийн салбар бүлгүүдийг шинээр нээсэн ажил багтана. Өнгөрсөн 4 жилд сургууль, цэцэрлэгүүдийн бүрэн ашиглагдахгүй байсан анги танхимуудыг ОНХС-аас хөрөнгө гарган засварлан шинэ бүлгүүдийг нээсэн. Өнөөдөр Дархан сумын хэмжээнд цэцэрлэгт хамрагдалт 85 хувьд хүрээд байгаа юм. Монгол улсын 330 сумаас Дархан сум ОНХС-аар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудаараа шилдгээр шалгаран энэ онд 356 сая төгрөгөөр шагнуулсан.

Үүнээс гэр хорооллын баг тус бүрд 10, орон сууцны хорооллын багуудад тус бүрд нь 15 сая төгрөгийг хуваарьлан нийт 14 ажил төлөвлөсний 10 ажил нь бүрэн дуусаж 4 ажил нь хийгдээд явж байна. Ингэж 18 багт хөрөнгийг тэгш хуваарилснаар өмнө нь 50-100 сая төгрөгөөр хийдэг байсан хүүхдийн тоглоомын талбайг 10-15 сая төгрөгөөр, 36 сая төгрөгөөр хийлгэж байсан 28-30 машины авто зогсоолыг 10 сая төгрөгөөр хийлгэсэн гээд бага хөрөнгөөр их ажлыг амжуулсан сайн жишээ олон байна. Гадаад, дотоодын зочид төлөөлөгчид яг одоо Дархан сумын 3 дугаар багт хийгдсэн хатуу хучилттай зам, гэрэлтүүлэг болон Ширээ нуруунд нээгдсэн 13 дугаар цэцэрлэгийн салбар бүлэг, Өргөө багийн "Жишиг хороолол-3" төслийн хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудтай газар дээр нь танилцан туршлага судалж байна.

ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН
АЖЛЫН АЛБА

ДАРХАН СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛОВ

Дархан сумын ГХУСАЗЗ-ийн ээлжит хурал 4 удаа болж, дараах асуудлыг хэлэлцэв.
Үүнд

1. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай
2. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар
3. Дархан сумын 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 багийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ
4. Дархан сумын 13 дугаар багийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг хэрхэн оролцуулж буй туршлага
5. Хулгайн гэмт хэргийн нөхцөл байдал, анхаарах асуудлын талаар
6. Дархан сумын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл



Хурлын эхэнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын мэдээллийг Дархан сумын ЕБС-уудын нийгмийн ажилтнуудын ахлагч Д.Бадамжав танилцууллаа.



МЭДЭЭЛЭЛ

Хууль сурталчлах аяны хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБС-уудын ахлах ангийн сурагчдын дунд тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай болон архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудыг сурталчлах ажлыг цагдаагийн хэсгийн байцаагч нартай хамтран зохион байгуулж 11 дүгээр ангийн 593 сурагчийг хамруулан мэдээлэл өгч ажилласан байна. Түүнчлэн цахим гадуурхлаас урьдчилан сэргийлэх үүднээс "Цахим гадуурхал цаашаа" үйл ажиллагааг зохион байгуулж "Цахим орчинд соёлтой оролцье" уриалгыг дэвшүүлэн ажилласан нь үр дүнгээ өгсөн гэв. Мөн танхайрах, хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ЕБС-ийн 7 дугаар ангийн 280 сурагч, 8 дугаар ангийн 297 сурагчийг хамруулсан лекцийг зохион байгуулж холбогдох хуулиудыг сурталчлан ажилласан байна.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Дархан сумын хэмжээнд "Нийтийн эргүүл" зохион байгуулж, иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, 2160 иргэнийг хамруулсан байна. Үүний үр дүнд гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэрэг буурах хандлага ажиглагдаж байгаа, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоо нэмэгдэж байгаа тухай мэдээллээ.

Багийн Засаг дарга П.Бадамханд, Б.Оюунчимэг, Р.Урангуа, Ч.Цэрэннадмид, Д.Хүрэлчимэг, Б.Нэмэхбаяр, Б.Батсуурь, Т.Ядамсүрэн, Б.Нямбаяр нарын хийсэн тайлан мэдээлэлтэй холбогдуулан зөвлөлийн гишүүд санал дүгнэлтээ хэлж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өглөө.



МЭДЭЭЛЭЛ

Тайлан мэдээлэл хийсэн багуудаас 13 дугаар багийн удирдлагууд, иргэд, олон нийтийн оролцоотойгоор нийтийн эргүүлийг тогтмолжуулж, өргөн хүрээтэй ажилладаг нь бусад багуудад туршлага болох ажил болсныг тэмдэглэж байв.

Дархан суманд 422 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оноос 48 гэмт хэргээр өссөн буюу 12,8 хувиар өссөн үзүүлэлт гарчээ. Гэмт хэргийн бүтцийн хувьд сүүлийн жилүүдэд хулгайлах, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах гэмт хэргүүд нийт гэмт хэргийн 57,1 % буюу ихэнх хувийг эзэлсэн байна.

Багуудын Засаг дарга нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гэмт хэрэгт өртөж болзошгүй иргэдтэй тулж ажиллах, солилцож буй мэдээлэл дээрээ тулгуурлан гэмт хэргийн нөхцөл байдлын судалгааг хийж, урьдчилан сэргийлэх ажлаа зохион байгуулах үүрэг өглөө.

МЭДЭЭЛЭЛ

БАТЛАВ.
ДАРХАН –УУЛ АЙМГИЙН ИТХ-ЫН
ДАРГА, ГХУСА33-ИЙН ДАРГА

Г.ЭРДЭНЭБАТ
/2017.04.03 Сар, Өдөр/
ТТЦ-0507

"ХАМТАРСАН БАГ-ИРГЭДИЙН АМЬДРАЛД" АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ, ТӨЛӨВЛӨГӨӨ

2017.04.03

Дархан

Зорилго: Дархан сумын хэмжээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэд төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхэд оршино .

Зохион байгуулагдах хугацаа: "Хамтарсан баг-Иргэдийн амьдралд" нэг сарын аяныг 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулна.

Оролцох байгууллагууд: Сумын ГХУСА33өвлөл, Хууль сахиулах байгууллагууд, Төрийн бус байгууллагууд, Дархан сумын ЗДТГ, 1-16, Өргөө, Малчин багуудын ИНХ-ын Тэргүүлэгчид, Засаг дарга түүний ажлын алба

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
1	"Хамтарсан баг-Иргэдийн амьдралд" аяны төлөвлөгөө удирдамж боловсруулж, ГХУСА33-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах	2017.04.06	Дархан сумын ЗДТГ, Цагдаагийн газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв /ХЭҮТөв/
2	Аяны төлөвлөгөө, удирдамжийг хамтарсан багуудад хүргэж танилцуулах	2017.04.10-ны дотор	Дархан сумын ГХУСА33өвлөл ЗДТГ
3	Аяны хугацаанд хийж гүйцэтгэх арга хэмжээг иргэд олон нийтэд сурталчлах, хэвлэлийн бага хурал зохион байгуулах	2017.04.10-ны дотор	Дархан сумын ГХУСА33өвлөл
4	Иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах	Аяны хугацаанд	Цагдаагийн газар, ХЭҮТөв
5	Гэр бүлдээ айдас түгшүүр төрүүлдэг, эрхэлсэн тодорхой ажилгүй, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй иргэдийг сургалтанд хамруулах	Аяны хугацаанд	Дархан сумын ЗДТГазар, Багууд
6	Хамтарсан багийн үйл ажиллагааг чиглүүлэх зорилгоор шалган туслах ажил зохион байгуулах	Аяны хугацаанд	Дархан сумын ГХУСА33, ЗДТГазар
7	Хамтарсан багийн 2017 оны эхний улиралд хийсэн ажлын тайлан мэдээллийг сонсох	2017.04.25 дотор	ГХУСА33, Дархан сумын ЗДТГ

МЭДЭЭЛЭЛ

8	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн судалгаа гаргах, үнэлэлт дүгнэлт өгөх	Аяны хугацаанд	Дархан сумын ЗДТГазар, Хамтарсан багууд
9	Хохирогчийг түр хамгаалах байр байгуулах асуудлыг шийдвэрлүүлэх	Аяны хугацаанд	Дархан сумын ЗДТГ
10	Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэх	4 дүгээр сард	Дархан сумын ЗДТГ
11	Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах сургалт бүрэн хамруулах	2017.04.25-ны дотор	Дархан сумын ГХУСАЗЗ, сумын ЗДТГ

Аяны үр дүнг тооцон, нэгтгэн дүгнэж шагнаж урамшуулах

№	Төрөл	Шалгуур үзүүлэлт	Байр	Шагналын хэмжээ
1	Шилдэг хамтарсан баг	1. Удирдамж, төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг зохион байгуулсан байх	Дархан сумын орон сууцны хорооллын хамтарсан баг	240,000 төгрөг
		2. Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхижүүлэн "Нийтийн эргүүл" хийсэн байх	Дархан сумын гэр хорооллын хамтарсан баг	240,000 төгрөг
		3. Иргэд олон нийт рүү чиглэсэн шинэлэг ажил зохион байгуулсан байх		
		4. Хамтарсан багийн гишүүд чадавхижуулах сургалтанд бүрэн хамрагдсан байх		

"ХАМТАРСАН БАГ-ИРГЭДИЙН АМЬДРАЛД" АЯНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Багууд	Нийт үнэ
1	Дархан сумын орон сууцны хорооллын шилдэг хамтарсан баг	240,000
2	Дархан сумын гэр хорооллын шилдэг хамтарсан баг	240,000
Нийт дүн		480,000

УДИРДАМЖ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛСАН,
ДАРХАН СУМЫН ИТХ-ЫН МЭРГЭЖИЛТЭН



Г.МӨНХГЭРЭЛ

“ХАМТАРСАН БАГ-ИРГЭДИЙН АМЬДРАЛД” АЯН ӨНДӨРЛӨВ

Дархан-Уул аймгийн ГХУСАЗЗ, Дархан сумын ГХУСАЗЗ-ийн 2017 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хамтарсан багуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх талаар салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах зорилтын хүрээнд “Хамтарсан баг –Иргэдийн амьдралд” 3 сарын аяныг зарлаж хүрээнд амжилттай хэрэгжүүлэн ажиллав.

Аяныг сумын ГХУСАЗЗ сумын ЗДТГ, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газрын мэргэжилтнүүдтэй хамтран дүгнэсэн байна. Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, сумын ЗДТГ-аас санал авсан бөгөөд Дархан сумын 2,13 дугаар багийг шалгаруулахаар дэмжсэн билээ.



Түүнчлэн Дархан сумын 15 дугаар багийн Хамтарсан баг иргэн Б-г газар, орон гэртэй болгох асуудлыг шийдвэрлэж, гурван хүүхэдтэйгээ хамт амьдрах боломжийг бүрдүүлжээ. Дархан сумын ГХУСАЗЗ-өөс “Хамтарсан баг - Иргэдийн амьдралд” аяны удирдамж, төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлж, гэр хорооллын багуудаас Дархан сумын 2 дугаар баг, орон сууцны хорооллоос Дархан сумын 13 дугаар баг тус тус шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналыг хүртээв.

Шагналыг Дархан сумын ИТХ-ын дарга Ж.Балжинням, сумын ИТХ-ын Тэргүүлэгч Д.Жамбалдорж нар гардуулан өглөө. Цаашид хамтарсан багууд Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлд илүү анхаарч иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллах шаардлагатайг онцлон хэллээ.